



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/142

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Соёлын төвийн барилгын их засвар (Орхон сум)-ийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга:

Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд:

Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Сүхбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл:

Б.Туяа (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга:

Г.Дэлгэр (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

